БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ**

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСЛИЙН

# МАГАДЛАЛЫН НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ

202 0 оны 03 дугаар сарын 11 ... өдөр

Дугаар 310/2020

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс: .......................

| | |
|---|---|
| **Барилга, байгууламжийн байршил, нэр, зориулалт:** | Сүхбаатар аймгийн Улбаян сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх "Ерөнхий боловсролын сургуулийн засвар"-ын ажлын зураг төсөл, төсөв<br>**ШИФР: TL-02/20** |
| **Хүчин чадал:** | **Засварын ажлын талбай:** S= 1000.44 м$^2$ |
| **Захиалагч:** | Улбаян сумын ерөнхий боловсролын сургууль |
| **Санхүүжилтийн эх үүсвэр:** | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар |
| **Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр:** | "Ти Эл прожект" ХХК |
| **Регистрийн дугаар:** | РД: 6250599 |
| **Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:** | 2023.01.25 |
| **Ажлын төрөл:** | 1.2.2, 1.2.4, 1.2.5, 1.2.6 заалтын дагуу |
| **Зураг төсөл боловсруулах үндэслэл:** | |
| Архитектур төлөвлөлтийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Сүхбаатар аймгийн Боловсрол, Соёл урлагийн газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр баталсан 003/ЗД-2020 дугаартай зураг төсөл боловсруулах даалгавар |
| Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | "Улбаян сумын Ерөнхий боловсролын сургууль"-ийн захиарал болон "Ти Эл прожект" ХХК-ийн захирал нарын хооронд 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан 08/2020 дугаартай зураг төсөл боловсруулах гэрээ |

**Барилга, байгууламжийн зураг төслийн бүрэлдэхүүн:**

| Зураг төслийн иж бүрдэл: | Зураг төсөл гүйцэтгэсэн байгууллагын нэр: | Магадлал хийсэн экспертийн нэр: |
|---|---|---|
| Төсөвт өртөг: | "Ти Эл прожект" ХХК<br>Х.Аюуш /Мэргэшсэн төсөвчин/ | С.Эрдэнэчимэг |

**Нэгтгэсэн дүгнэлт:** /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/

| | |
|---|---|
| Барилга байгууламжийн техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт; | Сүхбаатар аймгийн Улбаян сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх "Ерөнхий боловсролын сургуулийн засвар"-т:<br>- Одоо байгаа дээврийг хуульж, шинээр хавтгай дээвэр хийх,<br>- Хана, таазанд замаска хийж, эмульсэн будгаар будах,<br>- Хэсэгчилсэн вакуман цонх угсрах, |

| | |
|---|---|
| | будгаар будах,<br>- Радиотор солих,<br>- Аянга хамгаалалт, газардуулага угсрах зэрэг ажил хийхээр төлөвлөсөн байна. |
| Зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх; | **Чиглэл тус бүрийн орон тооны бус экспертийн саналыг зураг төсөлд тусгасан байдал:**<br>Эксперт нь норм ба дүрэм, стандартын шаардлагыг хангаж, экспертийн өгсөн зөвлөмжийн дагуу зураг төсөлд засвар хийсэн гэж дүгнэсэн байна. |
| Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх; | **Хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт**<br>Сүхбаатар аймгийн Уулбаян сумын "Ерөнхий боловсролын сургуулийн засвар"-ын ажил хийгдсэнээр хүүхдүүд ая тухтай цэвэр орчинд сурч хүмүүжих таатай нөхцөл бүрдэнэ. |

**Сүхбаатар аймгийн Уулбаян сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх "Ерөнхий боловсролын сургуулийн засвар"-ын ажлын нэгж өртгийн задаргаа**

| | Барилгын үндсэн хийц | Төсөвт өртөг /төг/ | Барилгын талбай /м2/ | Нэгж өртөг /төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | **а/. Барилга угсралтын ажил:** | | | |
| ББ | Барилга: 63 м x 15 м хэмжээтэй,<br>Дээврийн засвар<br>Талбайн хэмжээ: 1000.44 $м^2$<br>Үндсэн хийц: Шугаман суурьтай,<br>Гадна хана: 640 мм зузаан тоосгон,<br>Дээвэр: Хавтгай | 150,208,617 | 1000.44 | 150,142.6 |
| | **Хэсгийн дүн:** | **150,208,617** | | **150,142.6** |
| **4** | **г/. Зураг төслийн үнэ:** | | | |
| ЗТҮ | Зураг төслийн үнэ | 4,500,000 | | |
| | **Хэсгийн дүн** | **4,500,000** | | |
| | **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:** | | **154,708,617** | |

| | |
|---|---|
| **Төсөвт өртөг:** | Эксперт нь Сүхбаатар аймгийн Уулбаян сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх "Ерөнхий боловсролын сургуулийн засвар"-ын ажлын нийт төсөвт өртгийг **154 708 617** /Нэг зуун тавин дөрвөн сая долоон зуун найман мянга зургаан зуун арван долоо/ төгрөгөөр хянасан байна. |

**"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиох хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаарх дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".**

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын 1-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх "Ерөнхий боловсролын сургуулийн засвар"-ын ажлын зураг төсөл, төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНбД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНбД 81-95-12/-ийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, нэгтгэсэн дүгнэлт бичсэн болно.

Нэгтгэсэн дүгнэлт нь экспертүүдийн **2** хуудас магадлалын хавсралт дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ | Ц.АМАРСАНАА |
| БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ДЭД ЗАХИРАЛ | М.ИБРАЙ |
| НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА | Д.АЛТАНХУЯГ |
| БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН | Б.МӨНГӨНЗУЛ |

Барилгын хөгжлийн төвийн захирлын тушаал
Дугаар....
Хавсралт 1

Барилгын хөгжлийн төв
Барилга, байгууламжийн зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

Барилга, байгууламжийн зураг төслийн бүрдэл хэсгийн нэр **/Барилгын төсөв:/**
*Сүхбаатар аймаг Улбаян сум, 640 сурагчдын ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засварын ажлын зураг төсөл*

2020 оны 03 сарын 04 өдөр

| Д/д | Утга | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Барилга байгууламжийн нэр | Сүхбаатар аймаг Улбаян сум, 640 сурагчдын ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засварын ажлын зураг төсөл |
| 2 | Барилга байгууламжийн байршил, хүчин чадал | Сүхбаатар аймаг, Улбаян сум, 1-р баг |
| 3 | Зураг төслийн байгууллага | "Ти Эл прожект" ХХК |
| 4 | Зургийн шифр | |
| 5 | Хуудасны тоо | |
| **6. Дүгнэлтийн товч утга:** /Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоос/ | | |
| 1 | 6.12.1. архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар, загвар зураг, эх загвар зураг/эскиз/, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүдийг тодорхойлсон, техникийн нөхцөлтэй эсэх; | |
| 2 | 6.12.2. холбогдох мэргэжлийн байгууллагаар энэ дүрмийн 5.2-т заасны дагуу хянуулж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан эсэх; | |
| 3 | 6.12.3. барилга байгууламжийн архитектур төлөвлөлт, барилга бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь норм, нормативын баримт бичиг, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцлийн дагуу боловсруулсан эсэх; | |
| 4 | 6.12.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангуулсан эсэх; | |
| 5 | 6.12.5. барилгын ажлын талбай, үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, техник технологийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлагыг тусгасан эсэх; | |
| 6 | 6.12.6. инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаарх дүгнэлттэй эсэх; | |
| 7 | 6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангуулсан эсэх; | |
| 8 | 6.12.8. эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх дүгнэлт гаргасан эсэх; | |
| 9 | 6.12.9. зураг төслийн сонгосон шийдэл, магадлал хийх явцад экспертээс өгсөн нэмэлт, өөрчлөлтийн саналыг зураг төсөлд тусгасан эсэх. | Сүхбаатар аймаг Улбаян сум, 640 сурагчдын ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засварын ажлын зураг төсөл<br>Зураг төслийн "ТИ ЭЛ ПРОЖЕКТ" ХХК<br>Төсвийн дүн 153 496 992 төг<br>Төсөв зохиогч: Мэргэшсэн төсөвчин Х.Аюуш |

Дүгнэлт бичсэн
Эксперт № 9-41 С.Эрдэнэчимэг /............................/

Монгол Улс
Санж-Очирын Эрдэнэчимэг
ГЭРЧЛЭХ ТӨСӨВЧИН
055-95

2020 оны 03 сарын 04 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
**МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2**

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН НЭР
*Сүхбаатар аймаг Уулбаян сум, 640 сурагчдын ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засварын ажлын зураг төсөл*

2020 оны 03 сарын 04 өдөр

| Д/д | Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил | Биелэлт |
|---|---|---|
| 1 | Буулгах ажил: Үнсэн дулаалга буулгах ажил оруулах. Буулгасан барилгын хогны обьем бага байна. Үнс, цем.тэгшилгээ, хар цаас г.м-ийг оруулах. Хог зөөх зай их байна. Суманд 5-8 км орчимм байгаа байх. | Барилгын үндсэн дулаалга буулгах ажлыг оруулсан. Буулгасан барилгын хогны хэмжээг нэмж Үнс, цем.тэгшилгээ, хар цаас г.м-ийг оруулан хог тээвэрлэх зайг 5км-ээр бодов. |
| 2 | Дээврийн ажил:<br>- Дээврийн цем.тэгшилгээний зузаан бага байна. Хамгийн багадаа 40 мм байх.<br>- Хөөсөнцөр дулаалга хамгийн багадаа 15 см зузаан байх. Үнэ бага байна.<br>- Чулуутай, чулуугүй хар цаасны үнэ бага байна. Насжилтаар нь сонгох.<br>- Дээвэрт зарим хэсэгт хормой төмөр нөхөж оруулах.<br>- Дээврийн салхивчийн яндангийн өрлөг шавардлагын ажлыг дээврийн ажилд оруулж өгөх. Обьем бага байна.<br>- Цонхны ус хаялгын ажлын үнэлгээ сонголт буруу байна. Ус зайлуулах хоолойгүйгээр авах.<br>- Дээврийн уулзварын нөхөөсийг хар цаасаар хийхээр үнэлэх. | Дээврийн цементэн тэгшилгээний зузааныг 40 мм тооцов. - Хөөсөнцөр дулаалгыг 15 см байхаар тооцов. Үнийг нэмж тооцов. - Хар цаасны үнийг засав. - Дээвэрт зарим хэсэгт хормой төмөр нөхөж оруулав. - Дээврийн салхивчийн яндангийн өрлөг шавардлагын ажлыг дээврийн ажилд оруулж өгөв. Обьемыг нэмсэн. - Цонхны ус хаялгын ажлын үнэлгээний сонголтыг засав. - Дээврийн уулзварын нөхөөсийг хар цаасаар хийхээр үнэлэв. |
| 3 | Дотор заслалын ажил<br>- Цонхны амалгаа, хөөсөөр чигжих ажлын обьем их байна. Сольсон 2 ш цонхондоо тохируулж хийх<br>-Цонхны резин солих ажилд резины үнэ бага байна. | Цонхны амалгаа, хөөсөөр чигжих ажлын обьемыг багасгаж сольсон 2 ш цонхондоо тооцсон. -Цонхны резин солих ажилд резины үнийг нэмж оруулав. |
| 4 | Халаалтын ажил:<br>- Радиотор угсрах ажлыг экм-ээр үнэлэх. Радиотор Оросынх бол үнэ бага байна. Бас яндангуудын үнэ бага байна.<br>- Будах ажлын обьемыг зөв гаргах | Радиотор угсрах ажлыг экм-ээр үнэлэв. Радиоторын үнийг орос үнээр оруулав. Яндан хоолойн үнийг нэмж тооцов. - Будах ажлын обьемыг засав. |
| 5 | Аянга хамгаалалтын ажил:<br>- Аянга хамгаалалтын ажилд газар шорооны ажлыг оруулах. | Аянга хамгаалалтын ажилд газар шорооны ажлыг оруулав. |

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 9-41 .................................................. /С.Эрдэнэчимэг/

.......... оны ..... сарын ..... өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн .................................................. /Х.Аюуш/

2020 оны 03 сарын 05 өдөр

МОНГОЛ УЛС 98-176 Хорлоожавын АЮУШ МЭРГЭШСЭН ТӨСӨВЧИН ХУГАЦААГҮЙ

МОНГОЛ УЛС Санжсүрэнгийн Эрдэнэчимэг ЗӨВЛӨХ ТӨСӨВЧИН 055-96

БАТЛАВ:
Сүхбаатар аймгийн Боловсрол,
Соёл урлагын газрын дарга:
Л.Байгалмаа

**СҮХБААТАР АЙМГИЙН УУЛБАЯН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАРИЛГЫН ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

2020.02.14 Дугаар:003/ЗД-2020 Баруун-Урт

| | | |
|---|---|---|
| 1 | Зураг төсөл боловсруулах үндэслэл: | Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль<br>Монгол Улсын ЗГ-ын 2018 оны 388 дугаар тогтоол<br>Сүхбаатар аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br>Сүхбаатар аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр |
| 2 | Барилга байгууламжийн байршил: | Сүхбаатар аймгийн Уулбаян сумын төв 4-р баг |
| 3 | Захиалагч байгууллага: | Сүхбаатар аймгийн ЗДТГазар |
| 4 | Ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл боловсруулахад ашиглах материал: | Норм нормативууд:<br>• Олон нийт, иргэний барилга /БНбД31-03-03/<br>• Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД3.01-06-90/<br>• Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>Бусад холбогдохнорм дүрэм |
| 5 | Технологийн шийдэл: | Олон нийтийн иргэний барилгын зураг төсөл боловсруулах, норм дүрэм болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмийг баримтлан сүүлийн үеийн дэвшилтэд шийдлүүдийг сонгон ашиглах |
| 7 | Гүйцэтгэх ажлууд: | Гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсаны дараа тухай барилгын захиалагч, ашиглагч байгууллагатай зөвшилцөж нэмэлт санал авна.<br>Их засварын ажилд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ Үүнд:<br>-Дээвэр: Хуучин хавтгай дээврийг 100 хувь буулгаж БД 31-108-08 дагуу шинээр төлөвлөж гүйцэтгүүлэх.<br>-1-р давхрын хүзүүвчний дээврийг заадсыг завсарлахаар төлөвлөх<br>-Парпетны төмрийг 0,35 мм-с дээш зузаантай төмрөөр төлөвлөх<br>-Газардуулалга төлөвлөх<br>-Цонхны резинийг сольж гадна амалгааг засварлаж, усны хаялага төмөр төлөвлөх<br>-Нэгдсэн буулттай усны хаялага төлөвлөх |

| | | |
|---|---|---|
| | | -Агааржуулалтын янданг өндөрсгөхөөр төлөвлөх<br>-Дотор заслын ажил: 1,2-р давхрын 8 ангийн таазыг засварлаж сайн чанарын эмульсээр эмульсдэхээр төлөвлөх.<br>-2-р давхрын коридорын хана таазыг засварлаж сайн чанарын эмульсээр эмульсдэхээр төлөвлөх.<br>-Ариун цэврийн өрөөний агааржуулалтын систем, таазыг засварлхаар төлөвлөх.<br>-1-р давхарт ашиглагдах боломжгүй байгаа 2 өрөөнд дулаан тавьж ажилгаанд оруулхаар төлөвлөх<br>-Барилгын цоколын хэсгийг засварлаж будах |
| 9 | Инженерийн хангамжийн эх үүсвэр: | Бие даасан болно |
| 10 | Зураг төслийн үе шат, хугацаа | Зураг төсөл боловсруулах 1 үе шаттай. Гэрээнд заасан хугацаанд |
| 11 | Хөрөнгийн эх үүсвэр: | Улсын төсвийн хөрөнгө оруулалт |
| | Зураг төсвийн үнэ: | Зураг төслийн жишиг үнэ: БД81-16-12*2012 |
| 12 | Онцгой нөхцөл: | • Магадлалын зардал, техникийн нөхцөлийн төлбөр, ажлын зураг хяналт/ОБГ/-ын төлбөрийг зураг төсвийн үнэд багтсан гэж захиалагчаас үзнэ.<br>• Ажлын талбайтай газар дээр нь зайлшгүй танилцаж хэмжилт хийх бөгөөд өмнө хийгдсэн болон хийгдэх хэсэгчилсэн засврын ажлуудтай уялдуулах, |

Зөвшөөрсөн: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Б.Гансүх

Хянасан: Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, аймгийн Ерөнхий архитектор Ж.Батсуурь

Боловсруулсан: Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн Г.Гантөмөр

# СҮХБААТАР АЙМАГ, УУЛБАЯН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАРИЛГА

Улаанбаатар хот

---

2020 оны 02 сарын 14-ны өдөр

---

**Захиалагч**:

СҮХБААТАР АЙМАГ, УУЛБАЯН СУМ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Хаяг:
Монгол Улс,
Сүхбаатар аймаг, Уулбаян сум,
Ерөнхий боловсролын сургууль

Утас: +976 –99974008

**Гүйцэтгэгч**:

"ТИ ЭЛ ПРОЖЕКТ" ХХК

Хаяг:
Монгол Улс,
Улаанбаатар хот,
ХАН-УУЛ дүүрэг, 3-р хороо, Бармаш төв,
218 тоот хаяг

Утас: +976-11-77094336, 99994336
И-мэйл: info_tlp@yahoo.com
Байгууллагын гэрчилгээний бүртгэлийн дугаар: 9011705126
Регистр: 6250599
Захирлын утас: +976-11-99994336
Харилцах банк: Голомт банк
Дансны дугаар: 1415116560

БАТЛАВ:
ЗАХИАЛАГЧ
“УУЛБАЯН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН”-ийн
ЗАХИРАЛ
З.Эрдэнэчимэг ........./З.ЭРДЭНЭЧИМЭГ/

БАТЛАВ:
ГҮЙЦЭТГЭГЧ
“ТИ ЭЛ ПРОЖЕКТ” ХХК
ЗАХИРАЛ
........................./Л.БАЯРТ/

**БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар: 08/2020

2020 оны 02 дугаар сарын 14 ны өдөр Улаанбаатар хот

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ нэг талаас **“СҮХБААТАР АЙМАГ, УУЛБАЯН СУМ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ”** хаяг: Сүхбаатар аймаг, Уулбаян сумын нутагт байрлах /цаашид “Захиалагч” гэх/, нөгөө талаас **“ТИ ЭЛ ПРОЖЕКТ” ХХК** УБ хот, ХАН-УУЛ дүүрэг, 3-р хороо, Бармаш төв, 218 тоот хаяг, РД: 6250599 дугаартай /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар /хамтад нь Талууд гэх/ МонголУлсын “Иргэний хууль”, “Барилгын тухай хууль”, “Хот байгуулалтын тухай” хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн, энэхүү гэрээнд заасан нөхцөлийг харилцан тохиролцож, зөвшөөрсөнөөр гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал Захиалагч талын хүсэлтээр Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сумын нутагт байрлах **“СҮХБААТАР АЙМАГ, УУЛБАЯН СУМ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ”**-ийн засварын ажлыг зураг төслийг /цаашид “Зураг төсөл” гэх/-ийг захиалагчийн даалгаварын дагуу иж бүрэн боловсруулж захиалагч талд хүлээлгэн өгөх, захиалагч тал зохих үнэ хөлсийг төлөхтэй холбогдон гарах харилцааг зохицуулах, талуудын эрх үүргийг тодорхойлоход оршино.

1.3 Гэрээний хугацааг гэрээ батлагдсан өдрөөс хуанлийн хоногоор 30 хоногт багтаан гүйцэтгэнэ. ¯¿íä ðîëáîãäîõ áàéãóóëëàãóóäààð áàòëóóëæ ðýíóóëàõ õóãàöàà îðсон болно.

**Хоёр. Гэрээний нөхцөл**

2.1 Захиалагч тал зураг төслийн ажилд шаардлагатай архитектор төлөвлөлтийн даалгавар, захиалагчийн зургийн даалгавар, дэвсгэр зураг, геологын дүгнэлт, техникийн нөхцөл, технологийн даалвагаварыг Гүйцэтгэгч талд хүлээлгэн өгнө.
2.2 Гүйцэтгэгч тал нь зураг төслийг боловсруулж Захиалагчид хүлээлгэн өгнө.
2.3 Зураг төслийн иж бүрдэлд дараах ажлууд багтсан байна.
Үүнд:
- 2.3.1 Барилга архитектор
- 2.3.2 Дээвэр бүтээц
- 2.3.3 Төсөв

2.4 Барилгын зураг төслийн ажлын үнийг БД 81-16-12, БХБЯ-ны182-р тушаалын хавсралтыг үндэслэн хавсралт-1-ыг 2 тал харилцан тохиролцов.
2.5 Зохиогчын хяналтыг тусгай гэрээгээр зохицуулна.

2.6 Энэхүү гэрээний хугацаа нь гэрээнд талууд гарын үсэг зурж тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилж эхлэх бөгөөд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, гэрээг дүгнэж акт үйлдсэнээр дуусгавар болно.

**Гурав. Төлбөрийн нөхцөл**

3.1 Талууд гэрээний үнийг 4'500'000 /НӨАТ орсон/ төгрөг байхаар тохиролцов.
3.1 Зураг төсөл дуусган актаар баталгаажуулж хүлээлгэн өгнө. Үүнээс хойш угсралтын компани шалгаруулах тендер явагдаж шалгарсан компани эхний санхүүжилтээс зураг төслийн мөнгийг 100% төлөхөөр талууд харилцан тохиролцов.
3.2 Барилгын зураг төслийг баталгаажуулах эрх бүхий байгууллага болох магадлагч байгууллагаар хянуулах зардал нь гэрээний үнэд орсон байна.

**Дөрөв. Захиалагч талын эрх, үүрэг**

4.1 Гүйцэтгэгч талыг гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
4.2 Батлагдсан эскиз, зураг төслийн ажлын хүрээний явцад хяналт тавьж, зааварчилгаа өгч, саналаа тусгуулах эрхтэй.
4.3 Захиалагч тал нь гэрээт Зураг төслийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл, техникийн нөхцлүүдийг зураг төслийн ажил эхлэхээс өмнө бэлэн болгож, гүйцэтгэгч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
4.4 Зураг төсөл боловсруулах мэргэжлийн хүмүүсийг барилгын талбайд хэмжилт, шинжилгээ судалгаа хийхэд нь зөвшөөрөл, нөхцөл боломжоор хангана.
4.5 Барилгын зураг төслийг эрх бүхий байгууллагууд болон экспертизээр хянуулах үед захиалагчийн зүгээс бүрдүүлж өгөх бүх бичиг баримтыг гүйцэтгэгч талд хүлээлгэн өгнө.
4.6 Өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан гүйцэтгэгч талд учруулсан хохирлыг хариуцан барагдуулах.
4.7 Энэхүү гэрээнд заасан хугацаанаас өмнө хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээг нэг талын санаачилгаар цуцлахгүй байх үүрэгтэй.
4.8 Гэрээг хэрэгжүүлэх явцад хугацаа, ажлын чанарын талаар удаа дараа доголдол дутагдал илэрч, тэдгээрийг засахтай холбогдсон зэрэг өөрчлөлт гарахгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгчид анхааруулах ба энэ нь төсөл хэрэгжүүлэх ажилд саад болсон хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзвэл гэрээг цуцлах асуудлыг дангаар шийдвэрлэх эрх эдэлнэ.
4.9 Гэрээний талуудын хамтын ажиллагааг алдагдуулахгүй байх, харилцан хамтран ажиллах зарчмыг баримталж ажиллах үүрэгтэй.

**Тав. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг**

5.1 Захиалагч талыг гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
5.2 Ажлын зургын зохиогчийн эрхийг гүйцэтгэгч тал эзэмшинэ.
5.3 Ажил гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.
5.4 Гэрээт ажлын зураг төслийг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэн, гэрээнд заасан хугацаанд захиалагч талд хүлээлгэн өгнө.
5.5 Зураг төслийг шалгах, хянах явцад болон барилгын ажлын гүйцэтгэлийн явцад зураг төсөлд алдаа илэрвэл түүнийг үнэ төлбөргүй засварлах
5.6 Зураг төслийг экспертизээр батлуулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
5.7 Өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан захиалагч талд учруулсан хохирлыг харилцан тохиролцож барагдуулах үүрэгтэй.
5.8 Энэхүү гэрээнд заасан хугацаанаас өмнө хүндэтгэн үзэх шалгаангүйгээр гэрээг нэг талын санаачилгаар цуцлахгүй байх үүрэгтэй.

5.9 Гэрээг хэрэгжүүлэх явцад захиалагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаагаас ажил зогсох хүртэлх тохиолдолд захиалагчид анхааруулах ба хүндэтгэн үзэх шалтгаан гэж үзвэл гэрээг цуцлах эрх эдэлнэ.

5.10 Гэрээний талуудын хамтын ажиллагааг алдагдуулахгүй байх, харилцан хамтран ажиллах зарчмыг баримталж ажиллах үүрэгтэй.

5.11 Батлагдсан ажлын зураг төслийг цаасан боло pdf файл хэлбэрээр тус тус 1 хувь хүлээлгэж өгөх үүрэгтэй.

## Зургаа. Хариуцлага

6.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь нөгөө талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

6.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хоног тутам 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө. Алдангийн нийт хэмжээ зураг төслийн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна

6.3 Захиалагчийн буруутай үйл ажиллагааны улмаас зургийн ажил саатсан хоногийг баталгаажуулж гэрээний хугацаанд дээр нэмж тооцно.

## Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1 Талууд энэхүү гэрээний үүргийн биелэлттэй холбогдон гарсан бүхий л маргааныг эв зүйгээр шийдвэрлэх эрхэмлэнэ.

7.2 Талууд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол улсын хууль тогтоомжинд заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

## Найм. Давагдашгүй хүчин зүйл

8.1.Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/ -ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

8.2.Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд 3 хоногийн дотор бичгийн хэлбэрээр нөгөө талдаа харилцан мэдэгдэнэ.

## Ес. Бусад зүйл

9.1.**Нэмэлт, өөрчлөлт:** Талууд нь гэрээгээр тохиролцоогүй болон тохиролцсон боловч өөрчлөх шаардлагатай гэсэн асуудлаар нөгөө талдаа бичгээр санал гаргаснаар харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээнд оруулсан аливаа өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

9.2.**Санал, хүсэлт:** Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл болон гэрээтэй холбогдон нэг талаас нөгөө талдаа гаргаж буй аливаа санал, мэдэгдэл, хүсэлтийг бичгээр үйлдэж 3-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлснийг хүчинтэйд тооцно.

9.3.**Гэрээний хууль:** Энэхүү гэрээгээр зохицуулаагүй асуудлыг Монгол улсын хууль тогтоомжоор зохицуулна.

9.4.**Гэрээний эх хувь:** Гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

**“СҮХБААТАР АЙМАГ, УУЛБАЯН СУМ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ”**

Нябо

............................... / н.Өнөржаргал/

Хаяг: Сүхбаатар аймаг, Уулбаян сум, Ерөнхий боловсролын сургууль

Утас+976–99974008, 99744689

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

**“ТИ ЭЛ ПРОЖЕКТ” ХХКомпани**

Ерөнхий Архитектор

............................... /О.Болор /

Хаяг: УБ хот, ХАН-УУЛ дүүрэг, 3-р хороо, Бармаш төв, 218 тоот

Утас: 99994336, 80095884

“ТИ ЭЛ ПРОЖЕКТ” ХХК

2020 оны 03-р сарын 12-ний өдөр Сүхбаатар аймаг

## Барилгын зураг хүлээлцсэн акт

1. Барилга байгууламжын нэр:Сүхбаатар аймаг, Улбаян сум, 640 хүүхдийн ерөнхий боловсролын сургуулын дээврийн засварын ажлын зураг төсөв
2. Зургийн шифр: TL -02/20
3. Зургийн иж бүрдэл

| Д/д | Барилын зургийн хэсэг | Хуудасны марк | Хуудасны дугаар |
|---|---|---|---|
| 1. | Нүүр хуудас | НХ | 1 |
| 2. | Ерөнхий төлөвлөгөө, зай хэмжээ | ЕТ | - |
| 3. | Өндөржилт, замын хучилт | | - |
| 4. | Барилга архитектур, технологи | БА | 10 хуу |
| 5. | Барилга бүтээц | ББ | - |
| 6. | Дотор халаалт салхивч | ХС | 5 хуу |
| 7. | Цэвэр бохир ус | ЦБУ | - |
| 8. | Хүчит төхөөрөмж | ХТ | 3 хуу |
| 9. | Дотор гэрэлтүүлэг | ДГ | - |
| 10. | Холбоо дохиолол | ХД | - |
| 11. | Гадна дулаан хангамж | ГД | - |
| 12. | Усан хангамж, ариутгах татуурга | УАТ | - |
| 13. | Гадна цахилгаан хангамж | ГЦ | - |
| 14. | Гадна холбоо дохиолол | ГТД | - |
| 15. | Бусад | | - |
| 16. | Барилгын технологи, зохион байгуулалтын төсөл | ТЗБ | - |
| 17. | Бохир усны цооног | | - |
| 18. | Төсөв | 1 дэвтэр | 1 дэвтэр |

**Баримт бичгийн иж бүрдэл:** Магадлалын нэгдсэн дүгнэлт 5 хуудас

Хүлээн авсан:

Сүхбаатар Аймаг: Боловсрол соёл урлагийн газрын дарга

/Л.Байгалмаа/

9054073 ◬ 2217147910

Хүлээлгэн өгсөн:

"Ти Эл Прожект" ХХК-ийн

Ерөнхий Архитектор......................../О.Болор/